

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 02-р сарын 26-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар санал хурааж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 сарын 23-ны өдөр 10 цагт Улаанбаатар хотод “БиДиСек ҮЦК” ХК-ийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a) Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
 - b) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
 - c) Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ–н гаргасан шийдвэрийг танилцуулах
 - d) Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
 - e) Хөрвөх нөхцөлтэй санхүүжилт татах тухай
 - f) ТУЗ-ийн 2020 оны төсөв батлах
 - g) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2019 оны 3 дугаар сарын 4-ны өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу

3 дугаар сарын 19–ний өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдрөөс 2019 оны 4-р сарын 23-ны өдөр хүртэл 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах, эсвэл харьяалагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 1 хоногийн өмнө мөн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчээс санал хүлээн авахаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар О.Амарсанаа гишүүнээр Б.Тэмүүлэн нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Компанийн Тэргүүн Дэд захирал Б.Лхагвадорж, тооллогын комиссын даргаар “БиДиСек ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Азбаяр, гишүүдээр “БиДиСек ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Д.Шүрэнцэцэг нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 02-р сарын 26-ны өдөр

Дугаар 3


Улаанбаатар хот

***Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан,
түүнд хийгдсэн хараат бус аудитын тайлангийн тухай***

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг хангалттай гэж үзсүгэй.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхийг ТУЗ – ийн дарга /Б.Лхагвадорж /-д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Б.ЛХАГВАДОРЖ/